

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
4. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	12
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	12
3.5.3 Авлага	12
3.5.4 Урьдчилгаа	13
3.5.6 Бараа материал	13
3.5.7 Үндсэн хөрөнгө	14
3.5.8 Өр төлбөр	14
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо	14
3.5.10 Орлогын данс	15
3.5.11 Зардлын данс	15
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	16
3.7 Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	17
4.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	17
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	18
4. Менежментийн захидал	19
4.1 Бараа материалын данстай холбоотой	19
4.2 тэтгэмжийн зардалтай холбоотой асуудал	19
4.3 Дотоод хяналттай холбоотой асуудал	19
4.4 Дотоод хяналттай холбоотой асуудал	20
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Д.ДЭЛГЭРСАЙХАН
ТАНАА

2021.03.25 № 01/1000
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр 9 зорилтын хүрээнд 65 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэл 94.8 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

\\10.10.10.20\Bichiq_Khereq\Yawsan_Bichiq\2021\0325auditin 2-R Gazar21.Docx

001052283

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,326,593.4	17,972,883.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	48,813.5	107,009.0
33	АВЛАГА	416,930.3	31,162.3
34	УРЬДЧИЛГАА	4,249.2	1,164,769.2
35	БАРАА МАТЕРИАЛ	6,856,600.4	9,174,761.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.0	7,495,181.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,783,133.2	16,023,692.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,783,133.2	16,023,692.6
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	11,160,925.7	13,762,219.6
39300	Биет бус хөрөнгө	1,622,207.5	2,261,473.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	20,109,726.6	33,996,575.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	51,659.8	107,203.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	51,659.8	107,203.4
41300	Өглөг	40,264.2	10,004.9
41400	Урьдчилж орсон орлого	11,395.6	97,198.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	20,058,066.8	33,889,372.4
51	Засгийн газрын хувь оролцоо	20,058,066.8	33,889,372.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	12,211,503.2	12,211,503.2
51200	Хуримтлагдсан үр дүн	7,226,980.0	21,167,084.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	619,583.7	510,784.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	20,109,726.6	33,996,575.7

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	33,368,017.0	49,485,561.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,504,912.1	1,519,415.6
120	Нийтлэг татварын бус орлого	6,504,912.1	1,519,415.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26,863,105.0	47,966,145.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	28,368,446.0	34,889,779.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,368,446.0	34,889,779.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,930,462.8	33,833,601.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,908,731.4	16,059,778.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,811,295.5	2,249,104.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,101,373.3	1,616,397.4
2104	Хангамж, бараа материалын зардал	1,284,252.0	1,177,840.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	121,615.5	284,624.1
2107	Томилолт, зочны зардал	125,924.9	34,503.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,101,044.9	4,545,165.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,476,225.3	7,866,187.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	437,983.2	1,056,178.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,999,571.0	14,595,781.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,132,584.6	730,005.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,866,986.4	13,865,775.7

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	49,806,326.8	63,062,898.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	22,922,158.4	15,021,787.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	22,922,158.4	15,021,787.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	22,922,158.4	15,021,787.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,063.4	74,965.3
120	Нийтлэг татварын бус орлого	21,063.4	74,965.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	26,863,105.0	47,966,145.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	49,346,811.5	49,684,012.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49,346,811.5	49,684,012.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,973,559.2	33,624,003.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,928,352.8	15,771,102.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,796,592.8	2,307,835.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,049,231.7	1,616,397.4
2104	Хангамж, бараа материалын зардал	733,439.2	680,590.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	171,824.6	1,105,242.8
2107	Томилолт, зочны зардал	125,924.9	34,503.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,303,669.1	5,434,784.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,864,524.3	6,673,546.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,373,252.3	16,060,008.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	459,515.3	13,378,886.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	469,397.0	13,320,690.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	469,397.0	13,320,690.5
2200	Дотоод эх үүсвэрээр	469,397.0	13,320,690.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-469,397.0	-13,320,690.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-159.3	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	159.3	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-10,041.0	58,195.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	58,854.5	48,813.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	48,813.5	107,009.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,180,949.3	0.0	16,180,949.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	10,131.0	0.0	10,131.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,191,080.4	0.0	16,191,080.4
Тайлант үеийн үр дүн	3,866,986.4	0.0	3,866,986.4
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,058,066.8	0.0	20,058,066.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	74,329.2	0.0	74,329.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,132,396.0	0.0	20,132,396.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-108,799.4	0.0	-108,799.4
Тайлант үеийн үр дүн	13,865,775.7	0.0	13,865,775.7
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,889,372.4	0.0	33,889,372.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,412,967,800.00	47,237,507,141.69	175,460,658.31	99.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	35,097,967,800.00	34,928,280,180.69	169,687,619.31	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34,231,510,200.00	34,070,904,489.69	160,605,710.31	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,556,542,700.00	15,547,609,119.94	8,933,580.06	99.9
210101	Үндсэн цалин	11,620,290,800.00	11,472,680,758.05	147,610,041.95	98.7
210102	Нэмэгдэл	2,674,517,900.00	2,827,812,502.93	(153,294,602.93)	105.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,261,734,000.00	1,247,115,858.96	14,618,141.04	98.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,328,090,600.00	2,303,158,494.26	24,932,105.74	98.9
210201	Тэтгэврийн даатгал	1,704,308,200.00	1,685,230,302.30	19,077,897.70	98.9
210202	Тэтгэмжийн даатгал	157,970,700.00	158,883,819.86	(913,119.86)	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	124,216,700.00	123,435,616.06	781,083.94	99.4
210204	Ажилгүйдлийн даатгал	31,053,600.00	30,507,087.01	546,512.99	98.2
210205	Эрүүл мэндийн даатгал	310,541,400.00	305,101,669.03	5,439,730.97	98.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,630,873,500.00	1,616,397,365.42	14,476,134.58	99.1
210301	Гэрэл, цахилгаан	165,574,400.00	158,036,530.78	7,537,869.22	95.4
210302	Түлш, халаалт	294,667,700.00	296,461,845.16	(1,794,145.16)	100.0
210303	Цэвэр, бохир ус	34,626,000.00	28,718,164.52	5,907,835.48	82.9
210304	Байрны түрээс	1,136,005,400.00	1,133,180,824.96	2,824,575.04	99.8
2104	Хангамж, бараа материалын зардал	680,270,200.00	677,811,388.39	2,458,811.61	99.6
210401	Бичиг хэрэг	335,939,400.00	335,388,253.10	551,146.90	99.8
210402	Тээвэр, шатахуун	74,347,200.00	74,345,280.00	1,920.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	130,394,700.00	128,232,804.29	2,161,895.71	98.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,159,000.00	7,791,500.00	367,500.00	95.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	131,429,900.00	132,053,551.00	(623,651.00)	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,411,960,000.00	1,410,917,035.00	1,042,965.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	447,057,900.00	446,758,828.00	299,072.00	99.9
210602	Тавилга	864,428,000.00	863,784,000.00	644,000.00	99.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	59,008,300.00	58,914,247.00	94,053.00	99.8
210604	Урсгал засвар	41,465,800.00	41,459,960.00	5,840.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	27,524,300.00	27,410,731.00	113,569.00	99.6
210701	Гадаад албан томилолт	1,917,300.00	1,917,244.00	56.00	100.0
210702	Дотоод албан томилолт	25,607,000.00	25,493,487.00	113,513.00	99.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,641,225,300.00	5,639,029,005.00	2,196,295.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,434,638,800.00	4,433,800,989.00	837,811.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	10,850,000.00	10,676,000.00	174,000.00	98.4
210803	Даатгалын үйлчилгээ	25,793,800.00	25,702,012.00	91,788.00	99.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,103,900.00	3,811,501.00	292,399.00	92.9

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	671,000.00	647,000.00	24,000.00	96.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	584,500,000.00	584,347,900.00	152,100.00	100.0
210807	Газрын төлбөр	2,823,400.00	2,810,503.00	12,897.00	99.5
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	205,300.00	44,000.00	161,300.00	21.4
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	577,639,100.00	577,189,100.00	450,000.00	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,955,023,600.00	6,848,571,350.68	106,452,249.32	98.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,914,088,500.00	6,807,941,200.68	106,147,299.32	98.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,935,100.00	40,630,150.00	304,950.00	99.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	866,457,600.00	857,375,691.00	9,081,909.00	99.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	866,457,600.00	857,375,691.00	9,081,909.00	99.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	575,868,200.00	572,923,391.00	2,944,809.00	99.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	290,589,400.00	284,452,300.00	6,137,100.00	97.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,315,000,000.00	12,309,226,961.00	5,773,039.00	100.0
220001	Барилга байгууламж	7,500,000,000.00	7,495,181,000.00	4,819,000.00	99.9
222001	Тоног төхөөрөмж	4,815,000,000.00	4,814,045,961.00	954,039.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	47,412,967,800.00	47,237,507,141.69	175,460,658.31	99.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	47,412,967,800.00	47,237,507,141.69	175,460,658.31	99.6
310001	Улсын төсвөөс санхүүжих	47,412,967,800.00	47,237,507,141.69	175,460,658.31	99.6
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,479	2,479	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	23	23	-	100.0
610001	Төсвийн байгууллага	23	23	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,228	1,228	-	100.0
620001	Удирдах ажилтан	40	40	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1,076	1,076	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	64	64	-	100.0
620004	Гэрээт ажилтан	48	48	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,228	1,228	-	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1,055	1,055	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	173	173	-	100.0

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,486,694,517.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,486,694,517.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,418,386,865.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,493,168.75
210101	Үндсэн цалин	27,499,333.00
210105	Гэрээт ажлын хөлс	195,993,835.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,677,180.00
210201	Тэтгэврийн даатгал	4,677,180.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,779,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,779,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,013,128.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,040,430.00
210604	Урсгал засвар	23,972,698.00
2107	Томилолт, зочны зардал	7,092,500.00
210702	Дотоод албан томилолт	7,092,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	244,897,000.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	244,897,000.25
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,894,434,388.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,894,434,388.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,307,652.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,472,840.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,472,840.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	58,834,812.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	33,613,800.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	25,221,012.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,486,694,517.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,486,694,517.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	567,539,117.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,919,155,400.00

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг газрын дарга Д.Дэлгэрсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үндсэн үйл ажиллагааны төлөвлөлтийг сайжруулах, өглөг авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, малын нас дэвшилтийг тооцох, нэг удаагийн тэтгэмж олгох хувь хэмжээг дотоод журамд тусгах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 3 дугаар сарын 05-аас 2021 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Б.Энхжин, аудитор Э.Бүгүнүтэй нар гүйцэтгэв.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 3 дугаар сарын 05-ний өдрийн 1/1470 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;
- Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлэх;
- Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит тогтмол хийж, үр дүнг сайжруулах;
- Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Улсын бүртгэлийн ерөнхий газар нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дотоод аудит нь 2020 онд харьяа 23 нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 27 зөвлөмж өгсөн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлогын дүн 33,368.0 сая төгрөгийн 1.0 хувь буюу 333.7 сая төгрөгөөр тооцов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг тайлант оны үйл ажиллагааны орлогын дүн 54,349.2 сая төгрөгийн 1 хувиар буюу 543.5 сая төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 48.8 сая, эцсийн үлдэгдэл 107.0 сая төгрөг болж 58.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	36.6	95.2	58.6	89.0
Арилжааны банк дахь харилцах	2.6	1.4	-1.2	1.3
Замд яваа мөнгөн хөрөнгө	9.6	10.4	0.8	9.7
Дүн	48.8	107.0	58.2	100.0

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт мөнгөн хөрөнгийн 89.0 хувь буюу 95.2 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл байна. Үүнээс Дундговь аймгийн УБХ 5.2 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн УБХ 0.2 сая төгрөг, Нийслэлийн УБГ 3.4 сая төгрөг, Улсын бүртгэлийн ерөнхий газар 86.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Мөнгөн хөрөнгө өмнөх оноос 58.6 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан тоног төхөөрөмжийн чанарын баталгааны барьцаа хөрөнгө байршуулснаас шалтгаалжээ.

Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын оны эцсийн гүйлгээ 10.4 сая төгрөгийг замд яваа хөрөнгөөр бүртгэсэн байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 416.9 сая, эцсийн үлдэгдэл 31.2 сая төгрөг болж, 385.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	1.2	0.1	-1.1	0.3
Татаас, санхүүжилтийн авлага	0.7	-	-0.7	-
Бусад авлага	415.0	31.1	-383.9	
Байгууллагаас авах авлага	372.5	16.9	-355.6	54.2
Хувь хүмүүсээс авах авлага	42.5	14.2	-28.3	45.5
Дүн	416.9	31.2	-385.7	100.0

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлага өмнөх оноос 95.4 хувь буюу 355.6 сая төгрөгөөр буурсан нь байгууллагаас авах авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 8.8 сая төгрөгийн авлага байна. Тухайлбал, Өвөрхангай аймгийн УБХ 2012 онд үүссэн байгууллагаас авах авлага 0.1 сая төгрөг, Сүхбаатар аймгийн УБХ 2006 онд үүссэн хувь хүнээс авах авлага 8.1 сая төгрөг, Дархан-Уул аймгийн УБХ 2008 онд үүссэн 0.6 сая төгрөгийн авлага байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 4.2 сая, эцсийн үлдэгдэл 1,164.8 сая төгрөг болж, 1,160.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилгаа	4.2	1,164.8	1,160.6
Урьдчилж гарсан зардал	4.2	1,164.8	1,160.6
Дүн	4.2	1,164.8	1,160.6

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 1,160.6 сая төгрөгөөр өссөн нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тавилга эд хогшил авах 824.2 сая төгрөгийг тендерт шалгарсан байгууллагуудад шилжүүлсэн боловч Ковид-19 цар тахлын улмаас тавилга, эд хогшлыг хүлээн авах боломжгүй нөхцөл байдал үүсэж урьдчилж гарсан зардлаар тайлагнасан, гадаад паспортын бэлдэц 328.3 сая төгрөгийн зардлыг урьдчилан шилжүүлсэн, спортын арга хэмжээ зохион байгуулах зардал 8.0 сая төгрөгийг урьдчилан шилжүүлснээс тус тус шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- Спортын арга хэмжээнд зориулж 8.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр шилжүүлсэн /Молор трейд ХХК/

3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 6,856.6 сая, эцсийн үлдэгдэл 9,174.7 сая төгрөг болж, 2,318.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	3,638.5	5,897.8	2,259.3
Тусгай зориулалтын материал	3,638.5	5,897.8	2,259.3
Бэлэн бүтээгдэхүүн	2,342.9	2,340.9	-2.0
Хангамжийн материал	855.0	906.0	51.0
Бичиг хэргийн материал	208.8	291.2	-82.4
Аж ахуйн материал	281.4	266.4	-15.0
Сэлбэг хэрэгсэл	233.6	205.8	-27.8
Түлш, шатах тослох материал	4.9	5.3	0.4
Бусад хангамжийн материал	126.2	137.2	11.0
Биологийн хөрөнгө	-	9.0	9.0
Мал амьтад	20.2	21.0	0.8
Дүн	6,856.6	9,174.7	2,318.1

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд Улсын Их Хурлын ээлжит сонгууль, Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд иргэний цахим үнэмлэхийн бэлдэц нөөцөлсөнтэй холбоотойгоор тусгай зориулалтын бараа материал өссөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Сүхбаатар аймаг дахь УБХ үнэт цаасны жилийн эцсийн үлдэгдлийг санхүүгийн тайлан, тодруулгад 1.6 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Ховд аймаг дахь УБХ шатахууны тайлан гаргаагүй, Өмнөговь аймгийн УБХ 4.3 сая төгрөгийн шатахууныг хяналтгүй зарцуулсан;
- УБЕГ малын нас дэвшилтийг бүртгээгүй.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 12,783.1 сая, эцсийн үлдэгдэл 16,023.7 сая төгрөг болж, 3,240.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	11,160.9	13,762.2	2,601.3
Биет бус хөрөнгө	1,622.2	2,261.5	639.3
Дүн	12,783.1	16,023.7	3,240.6

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 760.8 сая төгрөгийн барилга, байгууламжийг данс бүртгэлээс хассан, ХЗДХЯ-аас үнэ төлбөргүй балансаас баланст 162.8 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 2 ширхэг авто тээврийн хэрэгслийг хүлээн авсан байна. Төсвийн хөрөнгөөр 4,815.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авахаар батлагдаж, гүйцэтгэлээр 4,654.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авснаас шалтгаалан биет хөрөнгө нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө нэмэгдсэн нь Улсын Их Хурлын сонгууль, Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд программ хангамж худалдан авсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогүй /Нийслэлийн улсын бүртгэлийн газар 16.1 сая, Өмнөговь аймгийн УБХ 90.1 сая/

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 51.6 сая, эцсийн үлдэгдэл 107.2 сая төгрөг болж, 55.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр дүн	51.6	107.2	55.6
Ажилчидтай холбоотой өглөг	1.2	-	-1.2
Бараа үйлчилгээний зардлын өглөг	3.9	2.0	-1.9
Бусад өглөг	35.1	8.0	-27.1
Урьдчилж олсон орлого	11.4	97.2	85.8
Нийт дүн	51.6	107.2	55.6

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр данс нь байгууллагад өгөх өглөг 29.5 сая төгрөгөөр буурч, худалдан авах ажиллагааны хүрээнд хийгдсэн ажлын 97.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгөтэй холбоотой байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 20,058.0 сая, эцсийн үлдэгдэл 33,889.4 сая төгрөг болж, 13,831.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/-	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	12,211.5	12,211.5	-	36.0
Хуримтлагдсан үр дүн	7,227.0	21,167.1	13,940.1	62.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	619.5	510.8	-108.7	1.5
Дүн	20,058.0	33,889.4	13,831.4	100.0

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 13,831.4 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй шилжин ирсэн хөрөнгө болон тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна. Акталсан хөрөнгийн дахин үнэлгээний буцаалт 108.7 сая төгрөгөөр буурсан байна.

3.5.10 Орлогын данс

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 16,177.5 сая төгрөг буюу 48.3 хувиар өссөн байна.

Хүснэгт №8 Үйл ажиллагааны орлого

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт/+, бууралт -/-	Дүнд эзлэх хувь
Нийтлэг татварын бус орлого	6,504.9	1,519.4	-4,985.5	9.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	3.6	835.5	831.9	1.7
Бусад орлого	16.6	72.2	55.6	0.1
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - ҮХ	5,495.4	583.8	-4,911.6	1.2
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	989.3	27.9	-961.4	0.1
Тусламж санхүүжилтийн орлого	26,863.1	47,966.1	21,103.0	96.9
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	26,432.2	35,089.4	8,657.2	70.9
Хөрөнгийн санхүүжилт	288.7	12,309.2	12,020.5	24.9
Нэмэлт санхүүжилтийн орлого	142.2	567.5	425.3	1.1
Үйл ажиллагааны орлогын дүн	33,368.0	49,485.5	16,117.5	100.0

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгийн санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлогын данс байна.

Урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 8,657.2 сая төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос 425.3 сая төгрөгөөр өссөн нь сонгуулийн үйл ажиллагааны санхүүжилттэй холбоотой байна.

Хөрөнгийн зардал өмнөх оноос 12,020.5 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй барилга, байгууламж, тоног төхөөрөмжийн санхүүжилтыг олгосноос шалтгаалжээ.

3.5.11 Зардлын данс

Үйл ажиллагааны нийт зардал өмнөх оноос 6,521.3 сая төгрөг буюу 23.0 хувиар өссөн байна.

Хүснэгт №9 Үйл ажиллагааны зардал

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт/+, бууралт -/-	Дүнд эзлэх хувь
Урсгал зардал	28,368.5	34,889.8	6,521.3	100.0
Бараа, үйлчилгээний зардал	27,930.5	33,833.6	5,903.1	97.0
Урсгал шилжүүлэг	438.0	1,056.2	618.2	3.0
Үйл ажиллагааны зардлын дүн	28,368.5	34,889.8	6,521.3	100.0

Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа, үйлчилгээний бусад зардал 5,903.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнасан нь сонгуулийн үйл ажиллагааны зардалтай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Нийслэлийн улсын бүртгэлийн газар тайлант хугацаанд нийт 36.7 сая төгрөгийн зардлын ангиллыг буруу хуваарилан бүртгэсэн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчиж нийт 92.9 сая төгрөгийн худалдан авалт хийсэн;
- Ховд аймаг дахь УБХ төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарахад төрийн албанд ажилласан жилийг буруу тооцож 4.0 төгрөгийн илүү тэтгэмж олгосон;
- Сэлэнгэ аймаг дахь УБХ эрхэлж буй ажлыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг 15-25 хувиар тооцож 7.7 сая төгрөг олгосон;
- УБЕГ тендерийн баталгааны шаардлага хангаагүй байгууллагатай гэрээ байгуулсан, тендер шалгаруулалтын мэдээллийг цахим хуудсанд байршуулалгүйгээр 26.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан, барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн байгууллагад санхүүжилтийг олгохдоо чанарын баталгааны барьцаа болох гэрээний үнийн дүнгийн 5 хувийг суутгаж аваагүй байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Монгол улсын 2020 оны төсвийн тухай хуульд зааснаар 17,000.0 сая төгрөг улсын төсвийн орлогод төвлөрүүлэхээр батлагдаж, 11,621.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 68.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Улсын хэмжээнд цар тахал ковид-19 өвчний хүрээнд Засгийн газар болон Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа хатуу хөл хорио, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор мөн Иргэний улсын бүртгэлийн хууль тогтоомжид заасны дагуу иргэнд цахимаар бүртгэлийн лавлагаа үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор 2018 онд burtgel.mn цахим системийг нэвтрүүлж, иргэд 23 төрлийн лавлагааг үнэ төлбөргүй авах болсон зэргээс орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон урсгал зардлыг 37,012.1 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 64,603.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 1,914.2 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 52,288.2 сая төгрөгөөр тус тус бууруулж нийт 47,412.9 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 47,412.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 35,097.9 сая төгрөгийг урсгал зардалд, 12,315.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Улсын төсвөөс гүйцэтгэлээр 47,398.6 сая төгрөг олгогдож, 14.3 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 47,237.5 сая төгрөг буюу 99.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна. Зарцуулагдаагүй 161.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээнд 12,315.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 12,309.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Аймаг нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 567.5 сая төгрөгийг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 223.4 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 41.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 3,894.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 2,454.6 сая төгрөгийн мэдээллээс 2,292.7 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 161.9 сая төгрөгийн 8 мэдээллийг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 32.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 148.7 сая төгрөгийн 6 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт №10 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	32.8	1	32.8	-	-	100
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	6	148.7	6	148.7	-	-	100
Нийт	7	181.5	7	181.5	-	-	100

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 23 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 21 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага итгэл үзүүлж, 1 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулав.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 20, Ховд аймаг дахь УБХ “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байна.

Аудитаар нийт 677.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 0.2 сая төгрөгийн 12 алдааг аудитын явцад залруулж, 19.8 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 560.0 сая төгрөгийн 17 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 97.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 25 зөвлөмжийг хүргүүллээ.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

- Спортын арга хэмжээнд зориулж 8.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

- Спортын хэрэгсэл нийлүүлэх сонгон шалгаруулалтад тендерийн баталгааны шаардлага хангаагүй байгууллагатай гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д "Захиалагч энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрд шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Албан шаардлага хүргүүлэх

- Тайлант онд Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 161.9 сая төгрөгийн 8 ажил гүйлгээг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5 -д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Албан шаардлага хүргүүлэх

- Албан хаагчдын зуслангийн газарт хашаа барих ажлыг гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулахдаа тендер шалгаруулалтын мэдээллийг цахим хуудсанд байршуулаагүйгээр 26.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно", 33.2.1-т "үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Албан шаардлага хүргүүлэх

Төвлөрүүлэн захирагчийн харьяа түүврээр хамрагдсан төсвийн шууд захирагчдад өгсөн 4 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 БАРАА МАТЕРИАЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ

4.1.1 Илрүүлэлт:

Тайланд онд санхүүгийн тайланд малын нас дэвшилтийн бүртгэлийг хийгээгүй байна. Энэ нь УСНББОУС-27 Хөдөө аж ахуйн бүртгэлийн 38-д “Байгууллага нь биологийн хөрөнгө ба хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анх хүлээн зөвшөөрөлтөөс, түүнчлэн биологийн хөрөнгийн борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс тухайн тайлант үеийн туршид үүссэн олз, гарзыг тодруулна” гэж заасантай нийцэхгүй байна.

4.1.2 Эрсдэл:

Үнэ төлбөргүй орлогыг цаг тухай бүрд нь бүртгээгүйгээс тайлант оны эргэлтийн хөрөнгө буруу илэрхийлэгдэх

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд малын нас дэвшилтийг бүртгэж, тайлагнах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4.2 ТЭТГЭМЖИЙН ЗАРДАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.2.1 Илрүүлэлт:

Хууль зүй, дотоод хэргийн салбарын "Алба хаагч бүрд орон сууц" хөтөлбөрийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газраас 3 албан хаагчийн орон сууцны дэмжлэгт орон сууцны гэрээний үнийн дүнгийн 30 хувиар, 3 албан хаагчийн сууцны дэмжлэгт орон сууцны гэрээний үнийг 100 хувь төлж албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7-д "төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

4.2.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг хүртээмжгүй хуваарилах

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Дотоод журамд тэтгэмжийн талаар тодорхой тусгаж, хууль тогтоомжийн дагуу ажиллах

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4.3 ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

4.3.1 Илрүүлэлт:

Тайлант онд 24 байгууллагатай нийт 713.7 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, хэрэгжүүлсэн боловч гэрээний үүргийн биелэлтийг дүгнээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д “гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах” гэж заасантай нийцэхгүй байна.

4.3.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул байх, гэрээний гүйцэтгэл хангалтгүй байх

4.3.3 Өгсөн зөвлөмж:

Ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байгууллагуудтай гэрээт ажил дууссан тухай бүрд гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж, үр дүнг тооцож байх.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4.4 Дотоод хяналттай холбоотой асуудал

4.4.1 Илрүүлэлт:

Аймаг, нийслэлийн харьяа Улсын бүртгэлийн хэлтсүүдэд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 677.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 19.8 сая төгрөгийн акт тогтоож, 560.0 сая төгрөгийн албан шаардлага өгч, 97.7 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-т “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.5-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”

4.4.2 Эрсдэл:

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байх

4.4.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа төсвийн шууд захирагчид тавих дотоод хяналтыг сайжруулах

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2021.03.25

Аудитын
нэр:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020
оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код:

САГ-2021/20/СТА-ТТЗ

Шалгагдсан
байгууллагын нэр:

Улсын бүртгэлийн ерөнхий газар

Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
Улсын бүртгэлийн ерөнхий газар					
1	Спортын арга хэмжээнд зориулж 8.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр шилжүүлсэн.	8.0	Акт	УБЕГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Дэлгэрсайхан Ч.Баасансүрэн
2	Малын нас дэвшилтийн бүртгэлийг хийгээгүй.	-	Зөвлөмж	УБЕГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Дэлгэрсайхан Ч.Баасансүрэн
3	Хууль зүйн дотоод хэргийн салбарын “Алба хаагч бүрд орон сууц” хөтөлбөрийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газраас 3 албан хаагчийн орон сууцны дэмжлэгт орон сууцны гэрээний үнийн дүнгийн 30 хувиар, 3 албан хаагчийн орон сууцны дэмжлэгт гэрээний үнийг 100 хувь төлж албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн.	-	Зөвлөмж	УБЕГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Дэлгэрсайхан Ч.Баасансүрэн
4	Спортын хэрэгсэл нийлүүлэх сонгон шалгаруулалтад тендерийн баталгааны шаардлага хангаагүй байгууллагатай гэрээ байгуулсан.	20.0	Албан шаардлага	УБЕГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Дэлгэрсайхан Ч.Баасансүрэн
5	Албан хаагчдын зуслангийн газарт хашаа барих ажлыг гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулахдаа тендер шалгаруулалтын мэдээллийг цахим хуудсанд байршуулалгүйгээр 26.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна.	26.0	Албан шаардлага	УБЕГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Дэлгэрсайхан Ч.Баасансүрэн
6	Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 161.9 сая төгрөгийн 8 ажил гүйлгээг байршуулаагүй байна.	161.9	Албан шаардлага	УБЕГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Дэлгэрсайхан Ч.Баасансүрэн

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

7	Тайлант онд 24 байгууллагатай нийт 713.7 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, хэрэгжүүлсэн боловч гэрээний үүргийн биелэлтийг дүгнээгүй байна.	-	Зөвлөмж өгөх	УБЕГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Дэлгэрсайхан Ч.Баасансүрэн
8	Улсын бүртгэлийн ерөнхий газрын архив, үйлчилгээний цогцолбор төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн байгууллагад санхүүжилтийг олгоходоо чанарын баталгааны барьцаа болох гэрээний үнийн дүнгийн 5 хувийг суутгаж аваагүй.	-	Зөвлөмж	УБЕГ-ын дарга, Ахлах нягтлан бодогч	Д.Дэлгэрсайхан Ч.Баасансүрэн
Архангай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
9	Төрийн албан хаагч нарт холбогдох журамд заасан хэмжээнээс илүү мөнгөн шагнал олгосон.	0.7	Акт	Дарга, нягтлан бодогч	Ц.Жавхлант Г.Солонго
10	Төсвийн төслийг үндэслэлтэй боловсруулаагүй.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Ц.Жавхлант Г.Солонго
11	Тайлант жилийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгээгүй байна.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Ц.Жавхлант Г.Солонго
Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
12	Цалингийн зардлаас Нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 9081.2 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.	9.2	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Ц.Мөнхжаргал Г.Бат-Очир
13	Булган аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс				
14	Зочин төлөөлөгч хүлээж авахад төсвөөс хөрөнгө гаргаж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан.	0.01	Акт	Дарга, нягтлан бодогч	Ө.Хүрэлбаатар Г.Зулбадам
15	Хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардлаас худалдан авсан материалыг орлогодож аваагүй шууд зардалд бичсэн байна.	0.4	зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Ө.Хүрэлбаатар Г.Зулбадам
Говь-Алтай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
16	Шилэн дансны цахим хуудсанд тайланд онд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 1 мөнгөн гүйлгээ, орлогын 1 мөнгөн гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 5 мөнгөн гүйлгээ, орлогын 4 мөнгөн гүйлгээ, байгууллагын даргын Б/02, Б/05, А/02, А/19, А/27, А/33 дугаартай	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Г.Чүлтэмжамц Б.Алтанбагана

	тушаалыг тус тус мэдээлээгүй байна.				
17	Хөгжлийн бэрхшээлтэй 1 ажилтнаас 884.8 мянган төгрөгийн Хүн амын орлогын албан татвар суутгасан байна.	0.9	зөвлөмж	Татварын хэлтэс	
18	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас 774.4 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн боловч И-баримт аваагүй байна.	0.7	зөвлөмж	Санхүү, төрийн сангийн хэлтэс	
Дархан-Уул аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
19	Хэлтсийн албан хаагчдад ээлжийн амралтын олговрыг тооцохдоо 1055.9 мянган төгрөгөөр илүү, 13.1 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.	1.1	Акт	Дарга, нягтлан бодогч	Х.Хувьзаяа Ц.Оюунбилэг
20	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдээс 3 дугаар сард 7 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, 6.4.5, 6.10-д заасан мэдээллээс 3 дугаар сард 5.953.5 мянга, 9 дүгээр сард 17.009.9 мянга, 12 дугаар сард 5.953.5 мянга нийт 28.916.9 мянган төгрөгийн 4 гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байна.	28.9	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Х.Хувьзаяа Ц.Оюунбилэг
Говьсүмбэр аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
21	Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтын дүн зөрүүтэй байна.	-	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ж.Адилбиш Ч.Нарангэрэл
Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
22	Тайлант онд дээд шатны эрх бүхий албан тушаалтны бус өмнөх оны шийдвэрээр мөнгөн урамшуулал олгосон боловч санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгаагүй, дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүй байна.	1.0	Акт	Дарга, нягтлан бодогч	Д.Оюунбаяр З.Сарантуяа
23	Шилэн дансны цахим хуудсанд төсвийн байгууллагын төсөв, гүйцэтгэл, хэмрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын 34.948.2 мянган төгрөгийн 1, бусад 11, нийт 12 мэдээллийн хугацааг хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 71.363.8 мянган төгрөгийн 4 мэдээллийг огт байршуулаагүй байна.	71.3	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Д.Оюунбаяр З.Сарантуяа

24	Хөгжлийн бэрхшээлтэй 3 ажилтны цалингийн орлогоос хувь хүний орлогын албан татвар 2.424.8 мянган төгрөгийг суутган авсан байна.	2.4	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Д.Оюунбаяр З.Сарантуяа
Сүхбаатар аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
25	Томилолтын нөхөн олговрыг илүү бодож олгосон.	0.9	Акт	Дарга, нягтлан бодогч	Д.Борхүү С.Доржпагма
26	Улсын байцаагч нарын үнэт цаасны жилийн эцсийн үлдэгдлийг санхүүгийн тайлан, тодруулгад дутуу тайлагнасан.	1.6	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Д.Борхүү С.Доржпагма
Ховд аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
27	Тайлант онд албан хаагчдад цалингийн урьдчилгаа олгоод суутгаагүй, сахилгын арга хэмжээг дутуу суутгасан, үнэт цаасны тооцоог бодсон боловч, сумдын улсын бүртгэгч нараас орлого дутуу төвлөрүүлж, авлагаар бүртгээгүй байна.	1.4	Акт	Дарга, нягтлан бодогч	О.Хоролсүрэн Л.Жаргалмаа
28	Тус хэлтэс нь төрийн албан хаагчийн өндөр насны тэтгэвэрт гарахад төрийн албанд ажилласан жилийг буруу тооцож илүү тэтгэмж олгосон.	4.0	Акт	Дарга, нягтлан бодогч	О.Хоролсүрэн Л.Жаргалмаа
29	Тайлант онд 3 албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад нь ээлжийн амралтын тооцоо хийж, амралтын цалин бодож олгоогүй байна.	1.2	Акт	Дарга, нягтлан бодогч	О.Хоролсүрэн Л.Жаргалмаа
30	Шатахууны тайлан гаргаагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, бичиг хэргийн материалын зарцуулалтад тавих хяналт сул, төсвийг үрэлгэн зарцуулсан, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.	4.3	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	О.Хоролсүрэн Л.Жаргалмаа
31	Бараа материал худалдан авахдаа И-баримт авахгүйгээр худалдан авсан байна	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	О.Хоролсүрэн Л.Жаргалмаа
32	Байгууллагын дотоод хяналт хэрэгжээгүй, санхүүгийн ил тод мэдээлэл хангагдаагүй, үнэт цаасны тооцоо бодолт хангалтгүй, түлш шатах тослох материал, бичиг хэргийн материалын орлого, зарлагын зарцуулалтад дахин хяналт, шалгалт хийх шаардлагатай байна.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	О.Хоролсүрэн Л.Жаргалмаа
Хэнтий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					

33	Нягтлан бодогчид холбогдох хууль, журмыг зөрчиж 2 сарын цалингийн урамшуулал олгосон байна.	1.5	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Төрхүү Б.Ганцэцэг
34	Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас цалингийн зардалд шилжүүлж, эдийн засгийн ангилал зөрүүлэн гүйлгээ хийж өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	0.3	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Б.Төрхүү Б.Ганцэцэг
35	Тайлант хугацаанд оруулбал зохих 153 мэдээллээс хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, хугацаа хоцроосон 10 мэдээлэл байна.	24.5	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Төрхүү Б.Ганцэцэг
36	Байгууллагын дотоод хяналт нь тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байна.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Төрхүү Б.Ганцэцэг
Хөвсгөл аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
37	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө, зарцуулах аливаа шийдвэр"-д заасан мэдээллүүдийг тухай бүр мэдээлээгүй хугацаа хоцроож мэдээлсэн байна.	6.0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Эрдэнэбилэг Б.Мөнхдэлгэр
Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
38	Аж ахуйн материал дансанд 2.442.1 мянган төгрөгийн барилгын засварын материалыг буруу ангилан бүртгэж, зарцуулсан байна.	2.4	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Н.Энхбат Ч.Баярмаа
Дорноговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
39	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ НӨАТ-ын баримтыг аваагүй байна./цахим Е баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй/	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Ц.Тэгшжаргал У.Буянбат
Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
40	Тайлант хугацаанд оруулбал зохих 165 мэдээллээс хугацаандаа оруулсан 151 мэдээлэл, хугацаа хоцроосон 12 мэдээлэл байна.	-	Зөвлөмж	Даргын үүргийг түр орлог гүйцэтгэгч, нягтлан бодогч	Б.Сайхантуяа Х.Гарам
Орхон аймаг Улсын бүртгэлийн хэлтэс					
41	Шатахууны норм хүйтэн, дулааны улирлаас үл хамааран өөрчлөлтгүй, шатахуун зарцуулалтын жишиг нормоос өндрөөр тооцож олгосон байна.	0.8	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	М.Отгонбаяр Ц.Одгэрэл

Сэлэнгэ аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
42	Эрхэлж буй ажлыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг 15-25 хувиар тооцож олгосон.	7.7	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Саранчимэг Т.Мөнхзул
43	Шатахууны тайлангийн жолоочийн тооцооны хуудсанд ирсэн, явсан болон зарцуулсан цаг, спидометрийн заалтыг бүрэн хөтлөөгүй байна.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Саранчимэг Т.Мөнхзул
44	Шилэн дансны цахим хуудсанд байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай шийдвэрийн мэдээлэл, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн талаарх 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Б.Саранчимэг Т.Мөнхзул
Өвөрхангай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
45	1. Албан хаагч А.Мөнхтөрийн цалинг 184443 төгрөгөөр илүү, Г. Цэрэндоржийн цалинг 131675 төгрөгөөр дутуу нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд тусгасан байна. 2. Бичиг хэргийн зардлаас цэвэр бохир усны зардлыг зарцуулсан байна.	0.1	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	А.Мөнхтөр Ц.Цэнгэлбаяр
Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс					
46	1. Шатахууны тооцооллыг тулган баталгаажуулахад замын хуудсанд спидометрийн заалт, зарцуулсан шатахуун тусгаагүй 4.334.500.00 төгрөгийн шатахууныг норм тооцоолох боломжгүй, хяналтгүй зарцуулсан байна. 2. Үндсэн хөрөнгийн тайланд 45 ширхэг 90.107.310.28 төгрөгийн үлдэх өртөггүй тавилга, тоног төхөөрөмж, санхүүгийн програмд тусгагдсан байна.	94.4	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ч.Энхмөнх С.Батхүү
47	Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг тулган баталгаажуулахад 57.444.000.00 төгрөгийн гүйлгээ мэдээлээгүй байна.	57.4	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ч.Энхмөнх С.Батхүү
Нийслэлийн Улсын бүртгэлийн газар					

48	Албан хаагчдын ээлжийн амралтын цалинг бодохдоо амралт бодсон сарын цалинг дундаж цалинг тооцохдоо оруулан тооцсоноос 18 ажилтанд илүү цалин тооцон олгосон байна.	1.4	Акт	Захирал Нягтлан бодогч	Г.Анхныбаяр Б.Эрдэнэчимэг
49	Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлого, зарлагын 3 удаагийн 91.178.5 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансанд дутуу байршуулсан, 32 удаагийн гүйлгээгээр 378.965.1 мянган төгрөгийг шилэн дансанд байршуулахдаа холбогдох шийдвэрийг байршуулаагүй. төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 10 харилцагчтай холбоотой 482.172.3 мянган төгрөгийн гэрээний мэдээллийг байршуулаагүй байна.	-	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Г.Анхныбаяр Б.Эрдэнэчимэг
50	Тайлант хугацаанд гэрэл цахилгааны зардлаас 22.400.0 мянга, түлш халаалтын зардлаас 12.176.0 мянга, цэвэр бохир усны зардлаас 2.160.0 мянган төгрөг нийт 36.736.0 мянган төгрөгийн түрээсийн зардлыг тайлагнаж зардлын ангиллыг буруу хуваарилан бүртгэсэн байна.	36.7	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Г.Анхныбаяр Б.Эрдэнэчимэг
51	Тайлант онд 17.014.0 мянган төгрөгийн худалдан авалтыг харьцуулалтын аргаар, 75.891.5 мянган төгрөгийн худалдан авалтыг нээлттэй тендер сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй, цахим системд байршуулаагүй, шууд гэрээ байгуулсан байна.	92.9	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Г.Анхныбаяр Б.Эрдэнэчимэг
52	Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 14 нэр төрлийн 16.148.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогүй байна.	16.1	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Г.Анхныбаяр Б.Эрдэнэчимэг
53	Санхүүгийн тайланд тусгасан төрийн өмчийн дүн 0 төгрөг байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд 161.316.2 мянган төгрөгөөр тусгагдаж 161.316.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	-	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Г.Анхныбаяр Б.Эрдэнэчимэг
54	НИЙТ	677.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 03 дугаар сарын 25

№ 99/А0140068

Улаанбаатар хот

САТ-2021/20/СТА-ТТЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Спортын арга хэмжээнд зориулж 8,000,000.0 /найман сая/ төгрөгийн урьдчилгаа төлбөр шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төсвийг үр ашиггүй зарцуулсан 8,000,000.0 /найман сая/ төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Ахлах нягтлан бодогч Ж.Мөнхтүвшин нарт хариуцуулав.


ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Б.ЭНХЖИН
Э.БҮГҮНҮТЭЙ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25 № 422/А0140068

Улаанбаатар хот

САГ-2021/20/СТА-ТБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан хаагчдын зуслангийн газарт хашаа барих ажлыг гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулахдаа тендер шалгаруулалтын мэдээллийг цахим хуудсанд байршуулаагүйгээр 26.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-т "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно", 33.2.1-т "үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу тендер зохион байгуулах, худалдан авах ажиллагааны цахим системд үр дүнг тухай бүр мэдээлэх, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга Д.Дэлгэрсайхан, Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Б.Өэлүн-Үжин, ахлах нягтлан бодогч Ч.Баасансүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ
Б.ЭНХЖИН
Э.БҮГҮНҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25 № 423/А0170068

Улаанбаатар хот

САГ-2021/20/СТА-ТТЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Спортын хэрэгсэл нийлүүлэх сонгон шалгаруулалтад тендерийн баталгааны шаардлага хангаагүй байгууллагатай гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д "Захиалагч энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрд шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. ТБОНӨХБАҮХАТХ-ийг хэрэгжүүлж, тендер зарлахдаа шаардлага хангасан "Хамгийн сайн" үнэлэгдсэн байгууллагатай гэрээ байгуулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Б.Өэлүн-Үжин, ахлах нягтлан бодогч Ч.Баасансүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Б.ЭНХЖИН
Э.БҮГҮНҮТЭЙ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 424/АДИ40068

Улаанбаатар хот

САГ-2021/20/СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий нийт 161.9 сая төгрөгийн 8 ажил гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5 -д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.10-д "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан уургээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хуулийн хугацаанд ил тод, иж бүрэн байршуулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга Д.Дэлгэрсайхан, Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Б.Өэлүн-Үжин, ахлах нягтлан бодогч Ч.Баасансүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Я.САМБУУНЯМ
Б.ЭНХЖИН
Э.БҮГҮНҮТЭЙ